



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/353

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх олгох тухай

Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 14 дүгээр зүйлийн 14.1.4, 16 дугаар зүйлийн 16.2.5, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.3, 6.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Луус сумын “Буянт наран говь” ХХКомпаний зоогийн газарт архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл хугацаагаар олгож, ажиллах цагийн хуваарийг 09.00-21.00 хүртэл хугацаагаар баталсугай.

Хоёр. Согтууруулах ундаа түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /Б.Очирдорж/, Татварын хэлтэс /М.Туяацэцэг/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Луус сумдын Засаг дарга /Л.Цогзолмаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200719